



ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 05 -ны өдөр

Дугаар 1/35


Эрдэнэт

“Чиглэл хүргүүлэх тухай”

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6а, “Дархлаажуулалтын тухай” хуулийн 5.2 заалт, Улсын онцгой комиссын даргын 2011 оны “Коронавируст халдварт /ковид 19/-ын эсрэг вакцинаар дархлаажуулах тухай” 05 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдварт /Ковид-19/-ын дархлаажуулалтыг зохион байгуулах байнгын болон түр цэгүүдэд шаардлагатай хөвөн бөмбөлгийг БОЭТ-ийн Ариутгал угаалгын тасагт үнэ төлбөргүй ариутгаж, тасралтгүй хангаж ажиллахыг БОЭТ-ийн захирал /Б.Батсүх/-д даалгасугай.
2. Дархлаажуулалтад шаардлагатай хөвөн бөмбөлгийн захиалгыг БОЭТ-ийн Ариутгал угаалгын тасагт тухай бүр хүргүүлж ажиллахыг Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн төв /А.Баярхүү/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛООН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ